

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын 2019 оны ажлын тайлан

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувь нийлүүлэгчдийн хурлаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, гүйцэтгэх удирдлага нь өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж ирлээ.

Нэг. Санхүүгийн үйл ажиллагааны талаар

Тус компани нь энэ онд 188.2 сая төгрөгийн орлого олж, 233.7 сая төгрөгийн зардал гарган 45.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Тайлант хугацааны орлого нь өмнөх онтой харьцуулахад 30.3 хувиар буюу 81.9 сая төгрөгөөр буурсан байна.

2019 оны зун олон жилийн дундажаас сэрүүн, усархаг бороо үргэлжлэн орж, үер усны гамшигт үзэгдэл давтагдан цаг агаарын хувьд маш тааламжгүй байсан нь аялагчдын тоо эрс цөөрөх шалтгаан болсон.

Тайлант хугацаанд гарсан үйл ажиллагааны зардал 233.2 сая төгрөг, үйл ажиллагааны бус алдагдал нь 0.5 сая төгрөг байна. Үйл ажиллагааны зардлын 38.2 хувийг цалин нийгмийн даатгалын зардал, 21.7 хувийг шатахуун тээврийн зардал, 11.0 хувийг татвар үйлчилгээний зардал, 8.4 хувийг үндсэн хөрөнгийн элэгдэл, 5.6 хувийг даатгалын зардал, 2.7 хувийг томилолтын зардал, 2.6 хувийг боловсон хүчний зардал үлдэх 9.8 хувийг бусад зардал эзлэж байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 3.3 хувь буюу 7.4 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ оны байдлаар нийт 176.9 сая төгрөгийн хөрөнгөтэй байгаагаас эргэлтийн хөрөнгө 21.1 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 155.8 сая төгрөг байна. Нийт хөрөнгө нь өмнөх онтой харьцуулбал 16.3 хувиар өссөн байна. Эргэлтийн хөрөнгийн 1.2 хувь буюу 0.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 2.3 хувь буюу 0.5 сая төгрөгийг авлага 72.3 хувь буюу 15.3 сая төгрөгийг хангамжийн материал мөн 24.2 хувь буюу 5.1 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардал тус тус эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн 40.9 хувь буюу 63.7 сая төгрөгийг тээврийн хэрэгсэл, 38.0 хувь буюу 59.2 сая төгрөгийг барилга байгууламж 18.1 хувь буюу 28.1 сая төгрөгийг тавилга эд хогшил, 3.0 хувь буюу 4.7 сая төгрөгийг тоног төхөөрөмж эзэлж байна.

Эх үүсвэрийн хувьд 3,660.0 сая төгрөгийн өр төлбөр байгаагийн 97.0 хувь буюу 3,552.2 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн өглөг, 2.99 хувь буюу 107.5 сая төгрөгийн дансны өглөг, 0.01 хувь буюу 0.3 сая төгрөгийг татварын өглөг эзэлж байна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн талаар

“Хөвсгөл Усан зам” ХК нь 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 17 -ны өдрийн хооронд 1 орон тооны 16 гэрээт нийт 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж нийт 66.6 сая төгрөгийн цалингийн зардал гарч, нийгмийн даатгалын шимтгэлд 8.0 сая төгрөг төлсөн байна.

Гурав. Үйл ажиллагааны чиглэлээр хийсэн ажлууд:

“Хөвсгөл Усан Зам” ХК нь 2019 онд нийт 132 удаагийн аялалаар 7138 зорчигчдод үйлчлэж, 188,996,455.30 төг-н цэвэр орлого олж, орлогын төлөвлөгөөгөөг 82.7% биелүүлсэн. / Орлогын төлөвлөгөө 17.3%-иар тасарсан шалтгааныг 2019 онд Хөвсгөлд аялагчдын тоо эрс буурсантай холбон тайлбарлаж байна./

Үйл ажиллагааны зардал төлөвлөсөн зардлаас 31.6 сая төгрөгөөр буурсан нь төлөвлөгөөний биелэлттэй холбоотой.

2019 оны үйл ажиллагаанд 124.2 сая төгрөгийн зээл авч, 60 сая төгрөгийг төлж барагдуулсан.

2019 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. Хөвсгөл усан зам ХК-ийн нийтийн 00-н барилга , 6 модон гэрүүд, ВИП-1 буудлын модон барилгыг 23.1 сая төгрөгөөр засаж , өнгө үзэмж чанарын хувьд шаардлага хангах хэмжээнд хүргэсэн.
2. Усан онгоцны цахилгааны автоматүүдыг сольж , газар дээрхи ил цахилгааны шугамыг далдлах засварт 8.0 сая төгрөгийн засварын ажлыг хийж гүйцэтгэн цахилгааны талын аюулгүй байдлыг бүрэн хангалаа.
3. Усан онгоцны хэвийн жигд үйл ажиллагааг хангахын тулд ОХУ-н Эрхүү хотоос сэлбэг бусад шаардлагатай материалыг авчирч, 13.8 сая төгрөг зарцуулж урсгал засварыг хийсэн.
4. Далайн захиргаа, Онцгой байдлын албаны шаардлагын дагуу усан онгоц дээр аврах завь 17.0 сая төгрөгөөр авч байрлуулсан.
5. Далайн захиргаа, Онцгой байдлын албаны шаардлагын дагуу аврах хантааз 50ш, галын хор 10ш нэмж авч, усан онгоцон дээр аялагчдад ойр байлгах үүднээс аврах хантаазыг хадгалах цэгийг байгуулсан.
6. Амралтын өрөөнүүдийн тохилог байдал, амрагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлж шинээр модон ор 6ш, орны матрас 8ш, цагаан хэрэглэлийн иж бүрдэл 20 ширхэгийг нийт 2.9 сая төгрөгөөр худалдан авлаа.
7. Тохилог бие засах газар болон ариун цэврийн байгууламжийг хэвийн тогтмол ажиллуулах нөхцөлийг улам сайжруулан, сантехникийн засварт 5.3 сая төгрөгийн зардал гарган, засвар үйлчилгээ хийлээ.
8. Гэр, байруудын зуух, түлээний хайрцаг шинэчилж, өрөөнүүдийг тохижуулан 871,700 төгрөгийн урсгал засвар хийлээ.
9. Мөн аялагчидын ая тухыг хангах үүднээс усан онгоц дээр 10ш вандан сандал 2.600,000 төгрөгийн захиалан хийлгэж суурилуулсан.
10. Үйлчилгээний цэг, дэлгүүр, зоогийн газар болон баазын ойролцоо худалдаа эрхэлж буй иргэдийн ойр орчимд хогийн сав байрлуулж, хог хаягдалыг түр хадгалах санг стандартад нийцсэн ус бороо орохгүй, унахгүй зориулалтын материалаар доторлож, халдваргүйжүүлэн, ариутгал цэвэрлэгээг тогтмол хийж , усан онгоцон дээр болон модон гэрүүдийн гадна талбайд шаардлагад нийцсэн төмөр хогийн сав 650,000 төгрөгөөр 5 ширхэгийг авч байрлуулсан. .
11. Жилд 2 оос доошгүй удаа буюу өндөр ачаалалын үе болох 7,8 дугаар саруудад бааз орчмын уснаас мэргэжлийн байгууллагаар сорьц авахуулан шинжилгээг тогтмол хийлгэж байна.
12. Нуураас соруулан авч хадгалж байгаа ундны цэвэр усны ган савыг тогтмол хугацаанд цэвэрлэж ариутгаж хэвшсэн .
13. Жуулчны баазын эргэн тойронд ажиллаж байгаа нутгийн иргэдийн бараа бүтээгдэхүүнд эрүүл ахуйн шинжилгээ хийлгэж, стандартыг мөрдүүлж байхыг холбогдох газарт нь уламжилж хамтран ажиллаж байна.
14. “Хөвсгөл Усан Зам “ ХК нь татвараа хууль журмын дагуу тайлагнах үүргээ нэр төртэй биелүүлж 2019 онд НДШимтгэлд 12.1 сая төгрөг, ХХОАТатварт 5.9 сая төгрөг, НӨАТатварт 7.9 сая төгрөг, Ус ашигласны татварт 18.4 сая төгрөг, газрын татварт 0.2 сая төгрөг ҮХЭХАТатварт 0.3 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төлж , нийгмийн хариуцлагаа биелүүллээ.

Дөрөв. Хөвсгөл усан зам ХК-ийн 2020 онд Хөрөнгө оруулалтаар хийх ажлууд

Хөрөнгө оруулалт

Сүхбаатар хөлөг онгоцыг хөвөлтөнд бэлтгэх

1. Усан онгоцны том хөдөлгүүрийн гильц солих 2ш
2. Жижиг генераторын жижиг гильц солих 6ш
3. 150А -тай аккумулятор 2ш авах
4. Усан онгоцны чанга яригч солих 2ш

Сантехникийн засварууд

1. Жижиг ногоон вакуум насос 2ш авах
2. Нуураас цэвэр ус ёскость руу татах хоолой 100м, муфьт 10ш, булан 6ш, 32-н хаалт 2ш авах
3. Рестораны бохирын чайна шугам солих

4. Усны тоолуур суурилуулах

Барилгын ургсгал засвар

1. Хүрэн байшингийн суурь элэгдэж хазайсаныг засварлах
2. Няравын өрөөг бүрэн засварлах
3. Ажилчдын модон гэрийг цонхтой болгох
4. Галын цэг шинэчлэж барих /ГК/

Буудлын тохижилт

1. Орны матрас авах 5ш
2. Дэр авах 20ш
3. Жижиг хогийн сав авах 5ш
4. Гадаа нарлах түшлэгтэй модон сандал авах 5ш

Бусад:

1. 53 машины моторт засвар хийх, дугуй 4ш, радиатор 1ш, чагтан гол 4ш, тормосны барбан наклад 8ш
2. Галын хор 10 ш авах
3. Компьютер,принтер,хөгжим засуулж ажиллагаатай болгох
4. Төрийн далбааг шинэчлэх

Тав. Хянан шалгах Зөвлөлийн тайлан

Эрхэм хувь нийлүүлэгчид ээ!

Тайлант хугацаанд Хөвсгөл усан зам ХК-ийн Хянан шалгах зөвлөлийн гишүүнээр Норсмаа, Д.Дашцэдэн, Н.Отгонбаатар нар ажилласан бөгөөд Хянан Шалгах Зөвлөлөөс компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомж, компанийн дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, мөн компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-өөс өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, компанийн гүйцэтгэх удирдлага, албан тушаалтнуудын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаарх санал гомдол, хүсэлт ирээгүй болно.

Компанийн санхүүгийн үйл ажиллагааны талаар:

Тус компани нь энэ онд 188.2 сая төгрөгийн орлого олж, 233.7 сая төгрөгийн зардал гарган 45.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллалаа. Өмнөх онтой харьцуулахад орлого нь 30.3 хувиар буюу 82.0 сая төгрөгөөр , алдагдал нь 86.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна..

Зардал өмнөх онтой харьцуулахад 3.3 хувь буюу 7.4 сая төгрөгөөр өссөн. Тайлант хугацаанд гарсан үйл ажиллагааны зардал 233.2 сая төгрөг, үйл ажиллагааны бус алдагдал нь 0.5 сая төгрөг байна. Үйл ажиллагааны зардлын 38.2 хувийг цалин нийгмийн даатгалын зардал, 21.7 хувийг шатахуун тээврийн зардал, 11.0 хувийг татвар үйлчилгээний зардал, 8.4 хувийг үндсэн хөрөнгийн элэгдэл, 5.6 хувийг даатгалын зардал, 2.7 хувийг томилолтын зардал, 2.6 хувийг боловсон хүчний зардал үлдэх 9.8 хувийг бусад зардал эзлэж байна.

Авлага , өглөгийн талаар:

Оны эхэнд авлагын дүн 0.8 сая төгрөг байсан бол оны эцэст 0.5 сая төгрөг болж 37.5 хувиар буюу 0.3 сая төгрөгөөр буурсан байна. Дансны авлага нь НӨАТатварын авлага байна.

Оны эхэнд өр төлбөр 3,589,7 сая төгрөг байсан бол оны эцэст 3,660,0 сая төгрөг болж 0.2 хувиар буюу 70.3 сая төгрөгөөр өссөн байна. Өр төлбөрийг ангилж үзвэл 97.0 хувь буюу 3,552.2 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн өглөг , 2.99 хувь буюу 107.5 сая төгрөгийн дансны өглөг, 0.01 хувь буюу 0.3 сая төгрөгийг татварын өглөг эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

2019 оны 4-р улирлын байдлаар цэвэр дүнгээр 398.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй хуримтлагдсан элэгдэл 243.0 сая төгрөг ба тайлант жилд 19.6 сая төгрөгийн элэгдэл байгуулж зардалд тооцсон байна.

ТУЗ, Хяналтын зөвлөлийн төсвийн зарцуулалт:

Өмнөх оны бүх гишүүдийн хурлаар 2019 онд ТУЗ, Хянан Шалгах Зөвлөлийн зардалд 2.4 сая төгрөг төсөвлөснөөс тайлант хугацаанд 2.6 сая төгрөгийн зардал гарсан байна.

Нягтлан бодох бүртгэл ба тайлагнал:

Компанийн санхүүгийн тайлан баланс нь Монгол Улсын Сангийн Яамнаас батласан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт”, “Дансны үлгэрчилсэн заавар”-ын дагуу аккрузель сууриар бэлтгэгдсэн ба энэхүү тайлагналын суурь нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарттай нийцэж байна.

Компанийн 2019 оны санхүүгийн болон, удирдлагын үйл ажиллагааг санхүүгийн тайлан, анхан шатны баримт, холбогдох бусад баримт, тайлантай тулган хянахад Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль мөн компанийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэлээ хөтөлж санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд тайлагнаж харъяа санхүүгийн болон татварын байгууллагад тушаасан байна.